

Есүс мэндэллээ

-The Birth of Christ-



10Page

Тайлбарлагч

Эрт дээр үед Бетлехемийн Назар хотод нэн ядуу эмэгтэй Мариа амьдарч байлаа. Мариа сайхан сэтгэлтэй мужаан Иосефтэй сүй тавьсан байв. Тэр үед хөрш улсын Херод хаан Израиль улсыг захирч байв. Тэр үед Израильчууд хүнд хэцүү амьдралтай байв. Гэсэн ч тэд эрт дээр үеэс эхлэн Бурханы амлалтад бат итгэдэг хүмүүс байлаа.

Хүмүүс

Хэзээ нэгэн цагт нэгэн хүүхэд төрөөд бидэнд эрх чөлөөг авчирна. Тэр хүн биднийг аврахаар ирнэ.!



11Page

Тайлбарлагч

Нэгэн шөнө, Мариаг унтаж байтал гэнэт Габриел тэнгэр элч үзэгдэв.

Габриел

Мариа бүү ай. Чи Бурханы ивээлийг олжээ. Чи Бурханы Ариун сүнсээр хэвлийдээ үртэй болж хүү төрүүлэх бөгөөд түүнийг Есүс гэж нэрлэх болно. Бурхан Түүнд Давидын хаан ширээг өгөх болно.

Мариа

Би хараахан гэрлээгүй байтал яаж хүүхэдтэй болох билээ?

Габриел

Хүний хүү биш, Бурханы хүчээр хүү төрүүлэх болно. Тэр Бурханы хүү гэж дуудагдах болно.



12Page

Тайлбарлагч

Тэнгэр элчийн үгийг сонссон Мариа маш их гайхсан боловч Бурханы үгэнд дуулгавартай хандав.

Мариа

Бурхан минь, Би бол Таны боол. Бурхан та хэлснийхээ дагуу биелүүлэгтүн.

Тайлбарлагч

Тэр үед гэрлээгүй эмэгтэй хүүхэд төрүүлвэл чулуугаар шидүүлэн үхэх ч болох аймшигтай хэрэг байлаа. Мөн сүйт залуу Иосефт ч хаягдахаар байв. Гэвч Мариа гэрлээгүй байж хүү төрүүлэх болно гэсэн Бурханы үгэнд дуулгавартай байж харин ч талархалын магтаалыг өргөв. Төд удалгүй Мариа тэнгэр элчийн хэлсний дагуу хүүхэдтэй болов.

Иосеф

Үнэхээр... Ийм юм байж болохгүй. Яаж Мариа...Надтай гэрлэх гэж байж хүүхэдтэй болж чадаж байна. Ямар хэцүүн бэ? Ий Ий



13Page



14Page

Тайлбарлагч Мариатай сүй тавьсан Иосеф сайхан сэтгэлтэй зөвт хүн байлаа. Гэвч Мариа хүүхэдтэй болсныг сонсоод үнэхээр хэцүү байв. Иосеф Мариатай гэрлэж чадахгүй гэдгээ хэлэхээр шийджээ. Гэтэл нэгэн өдөр Иосефийн зүүдэнд тэнгэр элч үзэгдэв

Тэнгэр элч Давидын хүү Иосефоо! Мариаг эхнэрээ болгохоос бүү эмзэгтүн. Учир нь түүнд олдood байгаа нь Ариун сүнснийх юм. Түүнийг Хүү төрүүлэхэд, Есүс гэж нэрлэ. Тэр өөрийн ард түмнийг гэм нүглээс аварна

Иосеф Айн!! За заа ойлголоо.

.....

Тайлбарлагч Тэнгэр элчийн үгийн дагуу Иосеф Мариатай гэрлэв. Хэдэн сарын дараа Иосеф Мариаг дагуулан төрсөн нутаг Бетлехем уруу явах хэрэгтэй болов. Бүх хүмүүс нутаг уруугаа явж хүн амын тооллогод бүртгүүл гэж Ромын хаан тушаасан байв. Үдэш болж байсан ч Иосеф Мариа хоёрт хоноглох газар олсонгүй. Тэнд аль хэдийнээ маш олон хүмүүс очсон байлаа.

Иосеф Хоосон өрөө байхгүй юу??? Миний эхнэр төрч ч магадгүй байна. Гуйж байна. Жижигхэн өрөө ч болтугай байвал өгөөч....

.....



15Page

Тайлбарлагч Амрах газраа олоогүй тэр хоёр арай гэж малын саравч олж оров. Тэр шөнө Мариа бяцхан Есүсийг төрүүлэв. Бүх хүмүүсийг гэмээс аврах Бурханы хүү Есүс Христ ингэж мэндлэсэн юм.